



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

#### НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН МӨНХБАЯСГАЛАНТ ӨЭМТ-ИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: НТАГ-2026/194/НА-СТА-ОНӨҮГ

---

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот  
2026 он

НТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал  
Утас: 327734 Цахим [хаяг:nandinjargalq@audit.gov.mn](mailto:nandinjargalq@audit.gov.mn)  
Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр  
Утас:327734 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)  
Аудитын менежер: С.Гантөгс  
Утас: 315558 Цахим хаяг: [gantuguss@audit.gov.mn](mailto:gantuguss@audit.gov.mn)  
Ашид баланс аудит ХХК-ийн захирал: Л.Майцэцэг  
Утас: 99081568  
Цахим хаяг: [ashidbalance@gmail.com](mailto:ashidbalance@gmail.com)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
**НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Соёлын төв өргөө Г корпус, 5 давхар,  
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200  
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026-05-13 № 191  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
МӨНХБАЯСГАЛАНТ ӨЭМТ-ИЙН  
ДАРГА С.ОДЧИМЭГ ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Мөнх баясгалант ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Мөнх баясгалант ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээ үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ гүйцэтгэлд 141.4 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 373.7 сая төгрөг, бусад 33.6 сая төгрөг нийт 548.7 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Мөнх баясгалант ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 захирамжаар 82.4 хувь, ЭМДЕГ-аас эрүүл мэндийн анхан шатны тусламж,

үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 88.6 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ХӨРӨНГИЙН ДҮН		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	34,379,339.83	49,359,648.28
1.1.2	Авлага	27,889,900.69	5,695,357.70
1.1.6	Бараа материал	45,481,405.73	39,322,670.85
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	107,750,646.25	94,377,676.83
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	98,447,828.51	114,631,026.47
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	98,447,828.51	114,631,026.47
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	206,198,474.76	209,008,703.30
2	Өр төлбөр ба эздийн өмч		
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	255,148.28	-
2.2	Өр төлбөрийн дүн	255,148.28	-
2.3	Эздийн өмч	52,043,358.00	52,043,358.00
2.3.1	Өмч-төрийн	51,881,358.00	51,881,358.00
2.3.2	- хувийн	162,000.00	162,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	8,042,550.03	8,042,550.03
2.3.9	Хуримтлагдсан үр дүн	150,648,626.80	145,857,418.45
2.3.10	Тайлант үеийн үр дүн	(4,791,208.35)	3,101,376.82
2.3.11	Эздийн өмчийн дүн	205,943,326.48	209,044,703.30
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ӨМЧ	206,198,474.76	209,044,703.30

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого	496,940,301.02	492,859,999.10
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
3	Нийт ашиг /алдагдал/	496,940,301.02	492,859,999.10
5	Хүүгийн орлого	-	705,454.26
6	Бусад орлого	26,221,133.54	74,388,035.23
10	Ерөнхий ба удирдлагын зардал	527,952,642.91	564,852,111.77
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(4,791,208.35)	3,101,376.82
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(4,791,208.35)	3,101,376.82
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал)	(4,791,208.35)	3,101,376.82
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
27	Нийт орлогын дүн	(4,791,208.35)	3,101,376.82
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	496,303,290.71	547,963,680.39
1.1.5	Татаас санхүүжилтийн орлого	495,516,575.33	547,963,680.39
1.1.6	Бусад орлого	786,715.38	-
1.2	Мөнгөн зарлагын дүн	502,074,258.39	533,088,826.20
1.2.1	Ажиллагсад төлсөн	390,757,884.00	411,618,307.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	42,237,450.28	43,123,705.98
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	63,337,941.77	61,029,393.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	2,260,288.80	2,260,288.80
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,606,080.00	1,966,730.00
1.2.9	Бусад мөнгөн зардал	1,874,613.54	13,090,401.42
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(5,770,967.68)	14,874,854.19
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(4,120,000.00)	105,454.26
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		705,454.26
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,120,000.00	600,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,120,000.00	600,000.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
4	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(9,890,967.68)	14,980,308.45
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	44,270,307.51	34,379,339.83
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	34,379,339.83	49,359,648.28

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	52,043,358.00	8,042,550.03	150,648,626.80	210,734,534.83
Залруулсан үлдэгдэл	52,043,358.00	8,042,550.03	150,648,626.80	210,734,534.83
Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-	(4,791,208.35)	(4,791,208.35)
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	52,043,358.00	8,042,550.03	145,857,418.45	205,943,326.48
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(36,000.00)	-	-	(36,000.00)
Залруулсан үлдэгдэл	52,007,358.00	8,042,550.03	145,857,418.45	205,907,326.48
Тайлант үеийн ашиг (алдагдал)			3,101,376.82	3,101,376.82

2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	52,007,358.00	8,042,550.03	148,958,795.27	209,008,703.30
-----------------------------------	---------------	--------------	----------------	----------------

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Мөнх баясгалант ӨЭМТ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.2-т “Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна” гэж заасны дагуу эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг иргэн бүрд, аюулгүй, тэгш, хүртээмжтэй хүргэх үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Мөнх баясгалант ӨЭМТ нь “Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэж, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх замаар тэдний эрүүл мэндийн байдалд чанарын ахиц гаргаж, сэтгэл ханамжийг байнга нэмэгдүүлэх, улмаар ӨЭМТ-ийг хөгжүүлэх, бэхжүүлэх, тусламж үйлчилгээг өргөжүүлэн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх” зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант онд нийт үзлэгийн тоо 18,143, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 6,975, гэрийн идэвхтэй эргэлт 5,626, амбулаторийн үзлэг 2,463, идэвхтэй хяналт 2,672, гэрийн дуудлагаар үзсэн 407 хүнд анхан шатны тусламж үйлчилгээг хүргэсэн байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Нөхөрлөлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламжийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль, Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм болон бусад холбогдох хууль, тогтоомж, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сард “Эрүүл мэндийн даатгалын 2025 оны төсвийн хуваарийг шинэчлэн тогтоох тухай”;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 04 дүгээр тогтоол “жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга журам, шинэчлэн тогтоох тухай”;
- Эрүүл мэндийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 1-352 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн байгууллагуудад нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих журам”;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорилт гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт шалгуур үзүүлэлтийн дагуу хийгдсэн байна.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Дотоод аудитын албанаас 2 жилд нэг удаа хяналт шалгалт хийдэг бөгөөд тайлант онд хийгдсэн, зөрчил гараагүй байна. ӨЭМТ-ийн дарга батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээг хянаж баталгаажуулснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
НЭМГ-аас 2022 онд боловсруулсан Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан бэлтгэхэд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь ӨЭМТ-үүдийн онцлогийг тусгаагүй, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын холбогдох заалт, нягтлан бодох бүртгэлийн журмыг баримтлан боловсруулаагүй байна.	1	-	-	-	-	-	1						
Дүн	1		-	-	-	-	1		-	-	-	-	-